



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 10 он 02
сарын 04 өдөр

Дугаар 3Г-2/54

Улаанбаатар
хот

ЗАРИМ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ТАНАА

Түргэвчилсэн үнэлгээ
явуулах тухай

Өвөлжилт хүндэрч, гамшгийн зэрэгт хүрээд байгаа 12 аймгийн 65 суманд амьдарч байгаа хүүхэд, өсвөр үеийхний аж байдалд түргэвчилсэн үнэлгээ хийхээр зөвлөмж, аргачлалыг НҮБ-ын Хүүхдийн сан холбогдох байгууллагууд хамтран боловсруулсныг хүргүүлж байна.

Түргэвчилсэн үнэлгээг 2010 оны 2 дугаар сарын 10-ны дотор явуулж, дүнг сум бүрээр нэгтгэн Хүүхдийн төлөө газарт энэ сарын 12-ны дотор хүргүүлнэ үү. Зөвлөмжийг хавсаргав.

Хувийг: Хүүхдийн төлөө газрын дарга М.Тогтохнямд.



Монгол Улсын Шадар сайд

М.ЭНХБОЛД

Түргэвчилсэн үнэлгээ явуулах удирдамж:

Энэ үнэлгээ зудын гамшигт өртсөн 65 сум, орон нутагт амьдарч байгаа хүүхдүүдийн амьдрал байдал, тэдний тулгамдсан гол асуудал, яаралтай авах арга хэмжээг төлөвлөхөд үндэслэл болохуйц нэмэлт мэдээлэл цуглуулахад чиглэж байна.

Гамшигт өртсөн орон нутгийн иргэд хүүхдүүдийн байдал, хэрэгцээнд явуулсан түргэвчилсэн үнэлгээний дүнг цаашид авах арга хэмжээг төлөвлөх, нөөцийг бүрдүүлэхэд ашиглана.

Зудын үед хүүхдийг хэн асрамжилж байна, хүүхдийн эрүүл мэндийн хувьд анхаарах асуудал юу байна, хоол хүнс, дулаан хувцасны хангамж ямар байна, хүүхдүүд юу хүсч байна, дотуур байранд болон хамаатан садан, таньдаг айлд түр сууж амьдардаг хүүхдүүдийн хувьд гамшиг яаж нөлөөлж байна, тэдний сэтгэл санаа ямар байна. Орон нутагт хүүхдэд чиглэсэн ямар үйлчилгээ, бодитой тусламж үгүйлэгдэж байна, хүүхдийн гэр, сургууль, байр нь зудтай энэ үед тав тухтай байж чадаж байна уу, нэмэлт ямар арга хэмжээ авбал нийгмийн үйлчилгээ тогтвортой байх боломжтой гэж дүгнэж байгаа талаар орон нутаг, анхан шатны нэгжийн мэдээллийг авч нэгтгэх юм.

Удирдлага, зохион байгуулалт

Үнэлгээ энгийн аргаар, хурдан хугацаанд орчны мэдээлэлд үндэслэн гарна гэж үзэж байна. Түргэвчилсэн үнэлгээнд ажиллах багийг орон нутаг томилж мэдээллээ нэгтгэн гаргаж дамжуулах нь зүйтэй. Багийг засаг захиргааны байгууллагаас нийгмийн ажилтнуудын шууд оролцоонд түшиж, хийвэл илүү зохимжтой. Гэхдээ идэвх санаачилгатай, ажил хэрэгч, шуурхай ханддаг багш нарын төлөөлөл, эрхэлсэн албан тушаалтан, боломжтой бол иргэний нийгмийн байгууллага, хүүхэд, өсвөр үеийхний төлөөллийг ч оруулж болно. Иймд үнэлгээний баг хөдөөгийн малчид түүнчлэн сумын төвд байгаа өрх, отроор явсан өрхийн хүүхэд голлон анхаарах бөгөөд хүүхдийн гэр орон, асран хамгаалагчийн зудын үеийн байдал ямар байгааг хамтад нь харгалзахыг зөвлөж байна. Мэдээллийг цуглуулах баг ажил үүргээ хуваан авсны дараа ихэвчлэн айл өрхөөр сонгон орох, хүүхэд, хөгшидтэй уулзаж, ярилцах, боломжтой бол ярилцлага өрнүүлж, дүнгээ нэгтгэх нь илүү зохимжтой. Мэдээллээ газар дээр нь очиж судлах боломжгүй бол зарим иргэд, албан тушаалтны мэдээлэлд үндэслэж болно.

Мэдээлэл дамжуулах нэгтгэх хугацаа:

1. Мэдээллээ аймгийн Хүүхдийн төлөө төвүүдэд утас, фах, цахим шуудангаар яаралтай дамжуулна уу.
2. Хүүхдийн төлөө хэлтсүүд аймгийн төвийн сумын мэдээллийг 2 сарын 10-нд;
3. Бусад сумын мэдээллийг 2 сарын 11-нд ХТГ-т дамжуулсан байхад анхаарна уу.

Асуумж бөглөх заавар:

- Асуумжийг гамшигийн хэмжээнд хүрсэн сум тус бүрийн хувьд болон аймгийн төвийн сумын хувьд зааврын дагуу мэдээллээ ирүүлнэ.
1. Сумын төвд байгаа малтай, малгүй эмзэг өрх гэрт байгаа хүүхдүүдийг асран хамгаалж байгаа хүмүүсийн талаар тэдний нас, хөгжлийн бэрхшээлийн байдал, хүүхэд харах хандах боломж зэргийг тоймлон мэдээлнэ.
 2. Өрх гэрээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдийг дотуур байранд, хамаатан айлд, таньдаг айлд, бусад гэсэн байдлаар тооцож гаргах юм. Одоогоор сургуулийн амралт эхлэхэд байранд үлдэх хүүхэд байна уу. Тэдний үлдэж байгаа шалтгаан болон тэр хүүхдүүдэд хэрэгцээтэй зүйлийн талаар дэлгэрэнгүй мэдээлнэ. Дотуур байрны багш болон хүүхдүүдээс мэдээлэл авах нь зохимжтой. Хүүхдүүдээс нөхцөл байдлын талаар тодруулахдаа багш болон бусад хүмүүс нөлөө

- үзүүлэхгүй байхаар орчныг сонгох хэрэгтэй. Хүүхдүүдээ сонгохдоо янз бүрийн нас, хүйсийн төлөөллийг хангахад анхаарах. Хүүхдүүдээс өдрийг яаж өнгөрүүлж байгаа, өдөртөө хэдэн цагт ямар зүйл идэж ууж байгаа, ямар тогломоор тоглож байгаа, ямар ном уншиж байгаа, сэтгэл санааг нь зовоож байгаа зүйл байгаа эсэх талаар, тэднийг юу баярлуулж байгаа талаар асууж үнэлгээ өгөх нь зүйтэй.
3. Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн хувьд байдал ямар байна. Халамж анхаарлаас холдох эрсдэл байна уу? боломжтой бол тэдний нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр гаргаж, тулгамдсан гол асуудлыг тодорхойлох юм. Дээрхтэй адилаар 3-5 хүүхдээс асууж үнэлгээ өгөх боломжтой.
 4. Хараа хяналтгүй хүүхэд байгаа бол тэдэнд нэн шаардлагатай зүйлийг жагсааж тоймлох хэрэгтэй.
 5. Сумын төвийн зарим эмзэг нэг айл өрхийн хоол, хүнсний хангамжийг үнэлэхдээ хэд хэдэн өрх /5 хүртэл/-д өрхийн бүтэн өдрийн хоол хүнсний байдал, хүнсний хэрэглээний нэр төрөл, хэмжээ, үнэ өртөгийг тооцоолохыг хичээх хэрэгтэй.
 6. Сумын төвд байгаа амьдрал нь хүндэрсэн, олон хүүхэдтэй өрх хэр олон байна, өрхүүдэд болон хүүхдүүдэд тулгамдсан нийтлэг ямар асуудал байгааг ярилцлагаар тодруулж баримтжуулахыг эрмэлзэх хэрэгтэй.
 7. Хүүхдүүдийн хувьд хоол, хүнсний чанар, хүрэлцээ ямар байна, өвчлөл байна уу, ямар төрлийн эм, хэрэгсэл байна, дутагдах , олдоц ховор эм, хэрэгсэл байна уу? сэтгэлзүйн хувьд асуудал гарч байгаа ажиглагдаж байна уу .Хүүхдүүдийн дулаан хувцас, ариун цэвэр ямар байна, эрүүл ахуйн нөхцөл хэвийн байж чадаж байна уу? Зэрэг нийгмийн гол асуудлыг тойрч байгаа мэдээлэлд тулгуурлан санал, дүгнэлтээ гаргана.Дээрх өрхүүдэд чиглэсэн ямар арга хэмжээ орон нутагтаа авч чадаж байгаа, тэр нь ямар хугацаанд үргэлжлэх боломжтойг мэдээлэлдээ дурдана. Цаашид ямар арга хэмжээ авахыг хүсч байгаа талаар товч тайлбарлавал сайн байна.
 8. Сургууль, цэцэрлэг, дотуур байр өдөртөө хэр дулаан байна. Хэмжих боломжтой бол хэмжиж өгнө үү. Хүүхдүүд гадуур хувцасгүй байх боломжтой юу. Боломжгүй бол анги танхмын хэдэн хувь хүйтэн, хүүхдүүдийн хэдэн хувь даарах нөхцөлтэй байгааг хэлнэ үү.
- 9-11. дугаар асуултад сургуулийн дотуур байранд суурилж, мэдээлэл цуглуулж нэгтгэн дүгнэх юм. Байранд амьдардаг хүүхдүүдийн хувьд хоол унд, дулаан хувцасны хангамж ямар байна, тэдний чөлөөт цаг өнгөрөөх орчин нөхцөлд номын сан, тоглоом наадгайн хүрэлцээний талаар байгаа нөхцөлөө сайн гаргаж, хэрэгцээтэй зүйлийн үндэслэлээ бичнэ.
10. Өсвөр насны 10 орчим хүүхдээс сэтгэл зүйн тестийг бөглүүлэн 3 болон 4 асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн хүүхдийн тоог мэдээлнэ үү.
- 12.Танай орон нутагт зудын үед хүүхдэд тохиолдож байгаа хүндрэл, тулгамдсан асуудлын талаар нийгмийн ажилтнууд зөвлөлдөн нэг кейсийг ирүүлнэ үү.

Хүүхдийн нөхцөл байдалд түргэвчилсэн үнэлгээ хийх асуумж
/заавар зөвлөмжтэй танилцана уу/

Аймаг, сум

Он, сар, өдөр

1. Хүүхдүүдийн асран хамгаалагчдын нийгмийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

-
-

2. Өрх гэрээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдийн тоо? Үүнээс:

1.1.	Дотуур байранд ер нь амьдардаг	
1.2.	Амралт эхэлсэн ч байранд байгаа хүүхэд хэд байна?	/нас, хүйсээр гаргаж өгөх/
1.3.	Хамаатан айлд	
1.4.	Таньдаг айлд	
1.5.	Бусад... (бичих)	

3. Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд хэд байна? (нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр) тулгамдсан гол асуудлууд юу байна?

-

4. Хараа хяналтгүй хүүхэд хэд байна? Тэдэнд нэн шаардлагатай зүйл юу байна вэ?

-

5. Сумын төвийн эмзэг өрхийн хоол, хүнсний хангамжид үнэлгээ өгнө үү. /зааврыг харна уу/

-

6. Сумын төвд байгаа амьдрал нь хүндэрсэн, олон хүүхэдтэй өрхөд тулгамдсан ямар асуудал байна вэ?

-

7. Дээрх өрхийн хүүхдүүдийн хувьд **хоол, хүнс, эрүүл мэнд, сэтгэлзүйн** ямар асуудлууд байна вэ? Дээрх өрхүүдэд чиглэсэн ямар арга хэмжээг орон нутгийн түвшинд авч байна вэ?

-

8. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны дулаан өдөртөө хэдэн хэм байна вэ?

-

9. Дотуур байранд үлдсэн хүүхдүүдийн хувьд хоол, хүнс, дулаан, усны хангамжийн байдлыг тодруулна уу.

-

10. Дотуур байранд байгаа хүүхдүүдийн хувьд ном, тоглоомын хангамж ямар байна вэ? /Дэлгэрэнгүй мэдээлэл, баримтад тулгуурлан өгнө үү.

-

11. Дотуур байранд байгаа болон сумын төвд байгаа өсвөр насны арваад хүүхдийн сэтгэл санааны байдалд тестээр үнэлж хариуг нь ирүүлнэ үү?

Сэтгэл зүйн байдлыг хянах хялбар арга

Мартаж чадахааргүй хүнд хэцүү, сэтгэл санааг чинь зовоосон үйл явдал тохиолдов уу? Хэрэв тийм бол сүүлийн үед :

1. Тэр тухай хар дарж зүүдэлж байв уу? эсвэл бодохыг хүсээгүй ч гэсэн бодогдож байв уу?	Тийм	Үгүй
2. Түүнийг бодохгүйг хичээж, уг явдал давтагдахгүй байх арга замыг хайж байв уу?	Тийм	Үгүй
3. Сэтгэл түгших, зовиурлах, гэнэт цочих явдал байна уу?	Тийм	Үгүй
4. Бусдаас хол, чимээгүй орчинд, ганцаар баймаар үе санагдах уу?	Тийм	Үгүй

Тестийн хоёр асуултанд “**тийм**” гэж, эсвэл зөвхөн 3-р асуултад (хэт цочимтгой байх) “**тийм**” гэж хариулсан бол үр дүн нь “**эерэг**” байна.

12. Нийгмийн ажилтнуудтай зөвлөн онцлог гэж үзэх нэг кейсийг сонгож ирүүлнэ үү.

Шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээллийг ирүүлж болно.

Хүүхдийн төлөө газар